БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ОЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

4.1 Ой зохион байгуулалтын ажлын зорилго, үе шат, баримтлах хууль, журам, дүрэм, заавар:

4.1.1. Зорилго: Ой зохион байгуулалтын ажил нь ойн сангийн талбай, нөөц, таксацын үндсэн үзүүлэлтийн өөрчлөлтийг хэсэглэл, ялгарал тус бүрээр нарийвчлан тогтоож, хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ойн мэдээллийн санг шинэчлэх, дараагийн арван жилд хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээний үндсэн төлөвлөлтийг нарийвчлан тогтоож, ой зохион байгуулалтын ажлын тайлан, хавсралт хүснэгт, ойн тархалтын зураг, ойн аж ахуйн арга хэмжээний зураг, байгаль хамгаалагчийн хариуцсан талбайн зураг, таксацын бичлэг зэргийг боловсруулах, захиалагчийн зүгээс өгсөн олон зорилтот ойн тооллогын давтан тооллогын цэгт хэмжилт тооллого хийх зорилготой болно.

4.1.2. Ой зохион байгуулалт, ойн бүртгэл тооллогын ажлын явцын болон гүйцэтгэлийн мэдээ, видео, фото зураг хэлбэрээр тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл цахим сошиал сувгаар мөн захиалагч байгууллага Ойн газрын хэвлэл мэдээллийн хариуцсан мэргэжилтэнд 10 хоног тутамд мэдээг тогтмол өгч хамтран ажиллана.

4.1.3. Ой зохион байгуулалт, ойн бүртгэл тооллогын ажлын тухайн багцад ажиллуулах инженер, техникийн ажилтныг ажилласан байна. /Тухайн багцын удирдах болон инженер, техникийн ажилтнууд ажиллуулаагүй тохиолдолд гэрээт ажлыг гүйцэтгэх боломжгүй гэж үзэн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна./

4.1.4. Ой зохион байгуулалтын ажил нь дараах үе шатаас бүрдэнэ:

- бэлтгэл ажил,
- хээрийн хайгуул судалгааны ажил,
- материал боловсруулалтын ажил,
- технологи ажилбар, баталгаажуулалт

4.1.5. Ой зохион байгуулалтын ажлыг дараах хууль тогтоом, заавар, журам, аргачлалын дагуу хийнэ. Үүнд:

- "Ойн тухай хууль",
- "Ой зохион байгуулалт хийх журам",
- "Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажилд тавих ерөнхий шаардлага" MNS6839:2020,
- Олон зорилтот ойн тооллогын ажил гүйцэтгэх заавар,
- Ой зохион байгуулалт ажил гүйцэтгэх заавар,
- Ой зохион байгуулалт хийх аргачлал,

4.1.2 Тендерийн багцын дугаар:

- **Багц-1**. Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцогт, Борнуур, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөр ширээт, Сүмбэр, Сэргэлэн, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Баянчандмань, Архуст сумдын ойн сангийн 1388.2 мянган га талбайд ойн бүртгэл тооллого, ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх

- **Багц-2.** Баянхонгор аймгийн Баян-Овоо, Галуут, Жаргалант, Өлзийт сумдын 33.4 мянган га шилмүүст, навчит ой, Эрдэнэцогт, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Богд, Бууцагаан, Жинст, Шинэжинст сумдын 787.3 мянган га заган ойн санд ойн бүртгэл тооллого, ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх
- **Багц-3** Нийслэлийн Налайх, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Багануур дүүргийн 116.3 мянган га навчит, шилмүүст ойн санд ойн бүртгэл тооллого, ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх
- **Багц-4** Дорноговь Алтанширээ, Даланжаргалан, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Зүүнбаян сумдын 116.8 мянган га, Дундговь аймгийн Өлзийт 32.8 мянган га нийт 149.6 мянган га заган ойн санд ойн бүртгэл тооллого, ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх

4.2 Бэлтгэл ажлын хүрээнд:

- Ой зохион байгуулалт хийх сумдын ойн санг 1:100 000-ны масштабтай байр зүйн зураг дээр хэсэглэлд хуваж, сум тус бүрээр баруун дээд хэсгээс эхлэн зүүн өмнө зүг рүү дэс дараалуулан дугаарлана. Тухайн сумын хилийн цэсийг www.egazar.gov.mn сайтаас татаж аван, ойн сангийн бүсийн хилийг өмнөх зохион байгуулалтын мэдээнд тулгуурлан (байгаль орчны эрх зүйн мэдээллийн сан www.eic.mn хандан өмнөх ой зохион байгуулалтын ажлаас хойш өөрчлөл орсон эсэхийг нарийвчлан гаргана) зуран хайгуулын ажилд хэрэглэх тойм зураг бэлтгэнэ.
- Ойн санг хэсэглэлд хуваахдаа сумдын хил залгаж байгаа газруудад тоот өндөрлөгүүдийг шулуун шугамаар холбох замаар хил тогтоосон хэсэгт энэ шугамын дагуу бусад хэсэгт ойн байршил, хэв шинж, тархалтын онцлогийг харгалзан байгалийн хилээр эсвэл хилийн зураг авалт хийх замаар тогтооно.
- Arc GIS, Q GIS болон бусад программ хангамжийг ашиглан ойн сангийн хилийг шинэчлэн зурж талбайг бодуулж гаргана. Газрын налууг үндсэн 4 бүлэгт I(0-15 хэм), II(16-25 хэм), III(26-35 хэм), IV(36 дээш хэм) хуваж, газрын чиглэлийг сургалттай ангиллаар ангилж ажилд бэлтгэнэ.
- Ойн сангийн газрын төрлийн өөрчлөлтийг Collect earth (LULUCF)- программ хангамжийг ашиглан 500м х 500м торлолыг ашиглан (100х100 метрийн 1 га бүхий дээж талбайд 5х5 нийт 25 цэг байрлах ба нийт 25 цэгийн 50%-иас буюу 13 цэгээс дээш цэгт таарсан тохиолдолд тухайн буусан газрын төрлөөр ангилна) үнэлгээ хийнэ. Газар ашиглалтын үнэлгээг ойн сангийн газрын төрөл тус бүрээр гаргаж өмнөх ой зохион байгуулалтын газрын төрлийн мэдээтэй харьцуулж захиалагчид танилцуулна.
- Ойн сангийн тархалт, газрын төрлийн өөрчлөлтийг газар зүйн мэдээллийн системийн программ ашиглан Засгийн газрын 2022.07.05-ны "Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай" 267-р тогтоолын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэж байгаа геодезийн хэмжилт, зураглалын ажилд олон улсын геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоо, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, газрын зураглалд дэлхийн хөндлөн меркаторын "UTM" тусгаг (UNIVERSAL TRANSVERS MERCATER) -ийг ашиглан зурж, газрын төрлийн өөрчлөлтийг нарийвчлан гаргаж дүн шинжилгээ хийнэ.
- Ойн сангийн өөрчлөлтийг гаргахдаа өмнөх ой зохион байгуулалтаар бүртгэж аваагүй орхигдуулсан, зөрүүтэй үнэлсэн, шинээр сэргэн ургасан, тархалтын хувьд зөрүүтэй зэрэг зүйлд ялгарал тус бүрд дүн шинжилгээ хийж бүртгэл хөтөлж, ойгоор бүрхэгдсэн талбай, ойгоор бүрхэгдээгүй талбайн ангиллын газрын төрөл тус бүрээр ялгарлын тоо талбайн хэмжээг нарийвчлан гаргана.
- Ойн санд хийсэн ойн аж ахуйн арга хэмжээний арга хэмжээг сүүлийн арван жилээр гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг холбогдох байгууллагаас гарган авч ойн сангийн зурагт нарийвчлан тусгаж ой зохион байгуулалтын техникийн нэгдүгээр зөвлөгөөнд танилцуулна.
- 1:100000-ын байр зүйн зураг дээр хуваасан хэсэглэлийн хилийг агаарын болон сансрын гэрэл зурагт шилжүүлэн зурж, хэвлэх, агаарын гэрэл зураг ашиглах бол ажлын талбай бэлтгэсэн байна.
- Ой зохион байгуулалт хийгдэх газрын ойн судлагдсан байдал мэдээ, зураглалтай танилцах, ойн тархалтын зураг, таксацийн бичлэгтэй нарийвчлан танилцаж холбогдох бэлтгэлийг хангана.

- Хээрийн судалгааны ажилд оролцох инженер техникийн ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, машин техник, багаж, тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх болон бусад холбогдох бэлтгэлийг хангасан байна.
- Ой зохион байгуулалт хийх газрын нөхцөл байдлыг судалж ажиллах хүн хүч, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хуваарилан, ой зохион байгуулалтын техникийн нэгдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулна. Тус зөвлөгөөнийг зохион байгуулахад тухайн багцад хамаарах засаг захиргааны нэгжийн ойн тархалтын талбай шинэчилсэн байдлаар гарсан байна. Ойн сангийн нийт талбай нь тухайн ажлын гүйцэтгэлийн нийт талбай байх ба газрын төрөл дотроо солигдож болох боловч нийт талбай солигдохгүй байхаар бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан байна.

4.3 Хээрийн хайгуул судалгааны ажлаар:

- Ойн санд хамаарах газрын хилийн заагийг Засгийн газрын 2015 оны 289-р тогтоолыг баримтлан тогтоох ба өмнөх ой зохион байгуулалтын судалгаанд хамрагдаагүй боловч Ойн хуульд заасны дагуу ойн санд хамаарах газруудыг мөн хамруулна.
- Ойн таксацын ажлаар ойн тархалт, таксацын үндсэн үзүүлэлт /ойн бүтэц, бүрэлдэхүүн, дундаж өндөр, голч, бонитет, насны анги гэх мэт/-ийг тодорхойлж, ойн төлөв байдалд үнэлэлт өгч, ойг хамгаалах, нөхөн сэргээх ойн аж ахуйн арга хэмжээг ялгарал бүрээр тогтоож, таксацын бичлэг боловсруулна.
- Геодези зураглалын ажлаар ойн санг хэсэглэлд хуваасан тойм зургийн дагуу хэсэглэлүүдийн уулзвар цэгийн газар зүйн байрлалын солбицлыг тогтоож, уул, нуруу, гол горхи, өндөрлөгүүдийн нэрийг тодруулах, байгалийн үл хөдлөх тогтцыг ашиглан хэсэглэлд хуваах боломжгүй газруудад хилийн зураг авалт хийнэ.
- Судалгаанд хамрагдаж байгаа газрын байгаль, цаг уур, нийгэм эдийн засгийн талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.
- Зориудаар ойжуулсан, хүний хүчин зүйлийн улмаас өөрчлөлт орсон зэрэг газруудад орчин үеийн дэвшилтэт технологи нисдэг камер ашиглан баримтжуулж захиалагчид хүлээлгэж өгөх.
- Байгуулсан дээж талбайн хэмжилт, түүний боловсруулалт, судалгааны үед баримтжуулж авсан гэрэл зураг, видео бичлэг, GPS-ийн track зэргийг CD-д буулгаж захиалагчид хүлээлгэж өгнө.
- Ойн санд байгаа унасан, хатсан модны нөөцийг ялгарал тус бүрээр тодорхойлж, хэмжилт тооллого хийх ба давтан зохион байгуулалтын ажлын үед хийгдсэн хэмжилт бүрийг баримтжуулж, захиалагчид архивын нэгж үүсгэн хүлээлгэж өгнө.
- Ойн тооллогын цэгт очсон фото зураг тэмдэглэл, замын зураг зэргийг захиалагчийн тавьсан шаардлагын дагуу баримтжуулж хүлээлгэж өгнө.

4.4 Материал боловсруулалтын ажлаар: "Ой зохион байгуулалтын ажлын тайлан", навчит шилмүүст ой бүхий сумыг 1:50 0000, заган ой бүхий сумыг 1:100 000-ны масштабтай ойн тархалтын зургийг сум тус бүрээр хийж доорх зүйлүүдийг тусгаж, тухайн багцад хамаарах аймгийн ойн сангийн нэгтгэлийг боловсруулан гаргана.

а. " Ой зохион байгуулалтын ажлын тайлан"-д:

- Ойн сангийн үндсэн үзүүлэлт, ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээ, ой хамгаллын арга хэмжээ, ойн аж ахуйн арга хэмжээ, дагалт баялгийн нэр төрөл, тархцын тоймчилсон судалгааг боловсруулан дүн шинжилгээ хийнэ.
- Ойн сангийн газрын төрөл, нөөцийн дүн, бонитетийн анги, өтгөрөл, насны бүлэг, насны анги, таксацын дундаж үзүүлэлт, таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт, насны бүлгийн өөрчлөлт зэрэг үзүүлэлтийг MS Excel программ хангамж дээр аж ахуйн төрөл тус бүрд (томьёолж) нэгтгэн ойн сангийн ОЙ программ хангамжийн дүн мэдээтэй тулгаж нягталсан байна.
- Ойн сангийн өөрчлөлтийг газрын төрөл тус бүрд гаргаж ялгарлын тоо, талбайн эмжээг нарийвчлан гаргаж, дүн шинжилгээ хийнэ. Ойн сангийн өөрчлөлтийн хүснэгт, өөрчлөлтийн зургийг газрын төрөл тус бүрд баримтжуулан төсөлд (хавсралт хүснэгтээр газрын төрлийн өөрчлөлтийг баталгаажуулна) тусгана.

- Ойн сангийн газрын төрлийн өөрчлөлтийг Collect earth (LULUCF)- программ хангамжийг ашиглан 500м х 500м торлолоор үнэлгээ хийж ой зохион байгуулалтын тоон мэдээтэй харьцуулж дүн шинжилгээ хийсэн байна.
- Тайланд ойн таксацын бичлэг /хэсэглэл ялгарал бүрээр/, талбай, нөөцийн нэгдсэн дүнгийн хүснэгт /хэсэглэл бүрээр/, хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээний түүвэр хүснэгтүүдийг хавсралтаар оруулсан байна.
- Судалгааны үед авсан ойн төлөв байдлын талаарх гэрэл зураг, ойн аж ахуйн арга хэмжээний зургийг тайланд хавсаргана.

б. "Ойн тархалтын зураг"-т:

- Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг зэргийг ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх зааварт заасны дагуу тусгана.
- Ойн хэсэглэлүүдийн хилийн уулзвар цэгийн газар зүйн солбицлыг тусгаж газрын хаялбарыг буулган ойн тухайн хууль-ийн 5.2-д заасан ойн захаас 100 м хамаарах газрын хилийг газар зүйн мэдээллийн системийн программ хангамжийн тусламжтайгаар (vapor zone) боловсруулан зурагт буулгана.
- Ой зохион байгуулалтын ажлын тайлан, зураг нь ой зохион байгуулалтын ажил гүйцэтгэх зааварт тусгасан ерөнхий агуулга, техникийн шаардлагуудыг бүрэн хангасан байна.
- Үр бэлтгэх, ойн арчилгаа, ойн цэвэрлэгээ, зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтад туслах зэрэг ойн аж ахуйн арга хэмжээг шаардлагатай бүх ялгаралд төлөвлөн ойн аж ахуйн арга хэмжээний зурагт тусгаж өгнө.
- Байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах талбайн зургийг боловсруулна.
- Ойн хэв шинжийн зургийг боловсруулна.
- Ой зохион байгуулалтын ажилд хэрэглэх хиймэл дагуулын мэдээ нь өндөр нарийвчлалын орон зайн шийд бүхий сүүлийн 1-2 жилийн хугацаанд авагдсан 6-9 сарын (ургамал ургалтын хугацааны), 80%-аас дээш тунгалагшилтай, судалгаа хийх газар нутгийг бүрэн хамарсан, алдаа гажилт байхгүй байна.
- Хиймэл дагуулын мэдээг орон зай байр зүйн засал хийж монгол орны 1:100000 масштабтай суурь зурагтай холбож давхцуулсан байна. Хиймэл дагуулын мэдээнд газрын төрлөөр нь сургалттай ангилал хийж, зурагт хаялбарыг буулгасан байна.
- Ойн таксацын бүх үзүүлэлтийг Ойн мэдээллийн сангийн программ хангамжид ашиглаж байгаа кодоор кодлон "Ойн таксацын карт"-д бичнэ.
- Материал боловсруулалтын ажлыг компьютерын программ хангамжаар гүйцэтгэх ба эх мэдээ нь одоо ашиглагдаж байгаа ойн мэдээллийн сангийн программд (DBF өргөтгөлтэй) хөрвөх боломжтой байна.
- Ойг ялгаралд хуваахдаа хэв шинж, таксацын дундаж үзүүлэлтээс хамааруулан 100 га-аас ихгүй хуваана.
- Ой зохион байгуулалтын ажлын тайлан, зургийг сум тус бүрээр 2 хувь хэвлэнэ. Ойн тархалтын зургийг 1:50 000-ны байр зүйн зургийн нэршлийн дагуу даавуун материал дээр хэвлэнэ.
- Хээрийн судалгааны ажлын эх мэдээ, ой зохион байгуулалтын ажлын тайлан, зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр CD-н дээр 1 хувь авна.

Техник хэрэгсэл мэргэшсэн инженер техникийн ажилтан болон бусад шаардлага:

Тендерт оролцогч нь доорх өөрийн гэсэн техник хэрэгсэл хүн хүчтэй байна.Үүнд:

- Хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тээврийн хэрэгслээр бүрэн хангагдсан байх
- Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан, 250.0 мян.га талбай тутамд ой зохион байгуулалтын ажлыг 2-оос доошгүй жилийн хийсэн, ойн аж ахуйн инженер эсвэл ой зүйч-1, ойн техникч-2, 400.0 мян.га талбай тутамд хиймэл дагуулын мэдээ боловсруулах болон газар зүйн мэдээллийн системийн мэргэжилтэн 1-ээс доошгүй байна.

- Төсөл зураг боловсруулалтын ажил гүйцэтгэх сүүлийн үеийн хүчин чадалтай компьютер, дижитайзер, плоттер, хиймэл дагуулын мэдээнд боловсруулалт ангилал хийх, зураг боловсруулах программ хангамжтай байна.
- Орчин үеийн дэвшилтэт технологи болох нисдэг камертай байх ба тухайн төхөөрөмжийг түрээслэн ашиглаж болно.
- Өмнөх оны тендерт оролцож гүйцэтгэгчээр шалгарч ажилласан бол ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн тухай захиалагчаас тодорхойлолт авсан байх
- Хээрийн судалгааны ажилд тухайн орон нутгийг хариуцсан ойн ангийн инженер техникийн ажилтнууд болон Монгол улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн оюутнуудыг оролцуулж дадлагажуулна.
- Ой зохион байгуулалтын ажлын тайлан, төсөл, зургийг "Ойн нөөцийн зөвлөл"-өөр хэлэлцүүлэн батлуулсны дараа орон нутагт ашиглах, хэрэглэх талаарх сургалт зохион байгуулж хүлээлгэж өгнө.
- Дээж талбайн хэмжилтийг гэрээний хавсралтад заагдсан нэг загварын хүснэгтээр хийж, эх хувь /гар бичмэл/-ийг тайланд хавсаргана.

Зураг-1

Ой зохион байгуулалтын материал боловсруулалтын ажлын ерөнхий бүдүүвч



Зураг-2

Ой зохион байгуулалтын зургийн ажлын бүдүүвч



Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

д/д	Зураг төслийн нэр	Агуулга
1.	Ажил явуулах талбайн зураг	Ой зохион байгуулалтын ажилд ашиглах хиймэл дагуулын мэдээллийн зураг
2.	Багаж техник тоног төхөөрөмжийн зураг	Хээрийн судалгааны болон материал боловсруулалтын ажилд ашиглах багаж техник, тоног төхөөрөмжийн зураг
3.	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зураг	Ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зориулалтаар ашиглах хувцас хэрэглэл, техник тоног төхөөрөмжийг гэрэл зургаар харуулсан байх
4.	Судалгааны ажилд ашиглах автомашинуудын зураг	Судалгааны ажилд ашиглах автомашинуудын зургийг тус бүрд нь харуулах

Үе шатны ажлын хуваарь

д/д	Ажлын нэр, тодорхойлолт	Багц	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	Багц-1	1388.2 мян.га	2025.06.15-ны дотор
		Багц-2	820.7 мян.га	2025.06.15-ны дотор
		Багц-3	116.3 мян.га	2025.06.15-ны дотор
		Багц-4	149.6 мян.га	2025.06.15-ны дотор
2	Ой зохион байгуулалтын техникийн I-р зөвлөгөөн зохион байгуулах (зөвлөгөөний шийдвэр гарсан байна)			2025.06.20-ны дотор
3	Хээрийн хайгуул судалгааны ажил	Багц-1	1388.2 мян.га	2025.09.15-ны дотор
		Багц-2	820.7 мян.га	2025.09.15-ны дотор
		Багц-3	116.3 мян.га	2025.09.15-ны дотор
		Багц-4	149.6 мян.га	2025.09.15-ны дотор
4	Тайлан, зураг боловсруулалтын ажил	Багц-1	1388.2 мян.га	2025.11.15-ны дотор
		Багц-2	820.7 мян.га	2025.11.15-ны дотор
		Багц-3	116.3 мян.га	2025.11.15-ны дотор
		Багц-4	149.6 мян.га	2025.11.15-ны дотор
5	Ой зохион байгуулалтын техникийн II-р зөвлөгөөн зохион байгуулах (зөвлөгөөний шийдвэр гарсан байна)			2025.11.16-ны дотор
6	Тайланг хэвлүүлж хүлээлгэн өгөх	Багц-1	1388.2 мян.га	2025.11.20-ны дотор
		Багц-2	820.7 мян.га	2025.11.20-ны дотор
		Багц-3	116.3 мян.га	2025.11.20-ны дотор
		Багц-4	149.6 мян.га	2025.11.20-ны дотор
7	Тайланг хэлэлцүүлэн баталгаажуулах	Багц-1	1388.2 мян.га	2025.12.01-ны дотор
		Багц-2	820.7 мян.га	2025.12.01-ны дотор
		Багц-3	116.3 мян.га	2025.12.01-ны дотор
		Багц-4	149.6 мян.га	2025.12.01-ны дотор
8	Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх (шийдвэр гарсан байна)			2025.12.05-ны дотор

Ой зохион байгуулалтын ажилд хамрагдах газрууд

Аймаг		№	Сумын нэр	Ойн сангийн талбай	Олон зорилтот ойн тооллогын цэгийн тоо
Төв	Багц-1	1	Алтанбулаг	2 692	270 цэгг 810 дээж талбай
		2	Аргалант	1 253	
		3	Батсүмбэр	147 222	
		4	Баяндэлгэр	38 125	
		5	Баянжаргалан	422	
		6	Баян-Өнжүүл	664	
		7	Баянхангай	864	
		8	Баянцогт	13 223	
		9	Борнуур	34 655	
		10	Жаргалант	32 539	
		11	Заамар	5 546	
		12	Лүн	2 207	
		13	Мөнгөнморьт	524 788	
		14	Өндөр ширээт	187	
		15	Сүмбэр	997	
		16	Сэргэлэн	872	
		17	Угтаалцайдам	10 091	
		18	Цээл	6 148	
		19	Эрдэнэ	554 573	
		20	Эрдэнэсант	499	
		21	Баянчандмань	10 566	
		22	Архуст	66	
Аймгийн нэгдсэн дүн				1 388 199	
Баянхонгор	Багц-2	№	Сумын нэр	Ойн сангийн талбай	Олон зорилтот ойн тооллогын цэгийн тоо
		1	Баян-Овоо	346	38 цэгт 114 дээж талбай
		2	Галуут	12 859	
		3	Жаргалант	3 972	
		4	Өлзийт	972	
		5	Эрдэнэцогт	15 286	
		6	Баянговь	1 519	998 цэгт 3992 дээж талбай
		7	Баянлиг	149 709	
		8	Баян-Өндөр	381 131	
		9	Богд	11 957	
		10	Бууцагаан	2 493	
		11	Жинст	1 180	
		12	Шинэжинст	239 291	
Аймгийн нэгдсэн дүн				820 715	
Нийслэл	Багц-3	№	Сумын нэр	Ойн сангийн талбай	Олон зорилтот ойн тооллогын цэгийн тоо
		1	Налайх	12 309	38 цэгт 114 дээж талбай
		2	Баянзүрх	56 973	

		3	Хан-Уул	6 521	
		4	Сонгинохайрхан	23 017	
		5	Чингэлтэй	4 070	
		6	Сүхбаатар	12 261	
		7	Багануур	1 106	
Аймгийн нэгдсэн дүн				116 257	
Дорноговь	Багц-4	№	Сумын нэр	Ойн сангийн талбай	Дээж талбайн тоо
		1	Алтанширээ	705	292 цэгт 1168 дээж талбай
		2	Даланжаргалан	112	
		3	Мандах	29 157	
		4	Сайхандулаан	9	
		5	Улаанбадрах	47 310	
		6	Хатанбулаг	16 491	
		7	Хөвсгөл	10 294	
		8	Эрдэнэ	1 223	
		9	Зүүнбаян	11 580	
Дундговь		1	Өлзийт	32 759	82 цэгт 328 дээж талбай
Аймгийн нэгдсэн дүн				149 640	
2025 оны нэгдсэн дүн				2 474 811	

Хянасан:

Ойн нөөцийн хэлтсийн дарга Г.Бат

Боловсруулсан:

Ойн бүртгэл тооллого, ой зохион байгуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Мичид